



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 67437

Улаанбаатар хот

Н.Мэндсайханд сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.16, 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10 дугаар зүйлийн 10.4, 10.6, 10.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Намхайжанцангийн Мэндсайхан нь Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь Хяналт шалгалтын газрын 2023 оны 58 дугаар дотоод албан бичиг, хяналтын улсын байцаагчийн 2023 оны 3315 дугаар дүгнэлт, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Н.Мэндсайхан үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахих талаар анхааруулахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /Б.Төгс-Эрдэнэ/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН



142302676